# АРХАНГАЙ БТСГ-ЫН СПОРТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Г.ЭНХ-АМГАЛАНГИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

2025.06.12

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| /д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | | Хэрэгжилт/ хүрсэн түвшин/ | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **ЗОРИЛТ 1. “ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ,СПОРТЫН БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ,САНХҮҮ НӨӨЦЫН УДИРДЛАГА ”** | | | | | | | |
| . | Арга хэмжээ 1.1 Хэлтсийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, төлөвлөх. | Төлөвлөгөө батлагдсан байна. | 2024 оны төлөвлөгө ө батлагдан хэрэгжсэн байна | 50% | 100% | Спортын хэлтсийн албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагааг удирдлагаар ханган ажиллаж байна. Тухайлбал тэмцээн уралдааны төлөвлөгөө гаргах, шүүгчийг томилох, техникийн зөвлөгөөнийг зохион байгуулах, 7 хоног, сар, улирал, жилийн ажлын хүрээнд спортын тэмцээн уралдааны хуваарийг гаргах зэргээр мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллаж байна. | 100% |
| . | Арга хэмжээ 1.2 Хэлтсийн зорилго, зорилтын биелэлтийг хангах. | Хэрэгжилт хангагдсан байна. | Хэлтсийн зорилго, зорилтыг тодорхойл ох, биелэлтий г хангагдсан байна. | 50% | 100% | Тус хэлтсийн зорилго, зорилтын хүрээнд тусгагдсан асуудлыг хэлтсийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолт, жилийн ажлын төлөвлөгөөнд холбогдох асуудлыг тусган оруулсан. Албан хаагчид хэлтсийн төлөвлөгөөний биелэлтийг ханган ажиллаж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Арга хэмжээ 1.3 Хэлтсийн ажилтнуудын үүрэг хариуцлагыг тодорхойлох, ажлын гүйцэтгэлийг хянах. | Гүйцэтгэлийг хянасан байна. | Хагас бүтэн жилээр албан хаагчдын үр дүнг хянасан байна. | 50% | 100% | Хэлтсийн удирдлагад байгаа 7 албан хаагчийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгон хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр үүрэг хариуцлагыг өндөржүүлэх талаар чиглэл өгч хяналт тавин ажиллаж байна. Улирал бүр албан хаагчид ур чадварын тайлан болон үр дүнгийн тайланг гарган холбогдох албан тушаалтанд хугацаанд нь хүргүүлж байна. | 100% |
| | Арга хэмжээ 1.4<br>Төрөөс баримталж буй спортын хөгжлийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх. | БТСТХуулийг хэрэгжүүлсэн байна. | Хэрэгжилт хангагдсан байна | 50% | 100% | Төрөөс баримталж буй спортын хөгжлийн бодлогыг орон нутагт амжилттай хэрэгжүүлэхийн тулд дараах урт, дунд, богино хугацааны бодлогын арга хэмжээ болон бодит хэрэгжилтэд чиглэсэн ажил болох спортын байгууламжуудыг өргөтгөх, шинэчлэх, биеийн тамирын заал, гадаа талбай, дасгалын тоног төхөөрөмжтэй талбай байгуулах, багш, дасгалжуулагч, хүүхэд, тамирчидыг шаардлага хангасан хувцас, тоног төхөөрөмжөөр хангах, дасгалжуулагч, биеийн тамирын багш бэлтгэх, чадавхжуулах, сумдын багш, дасгалжуулагчдад сургалт зохион байгуулах, мэргэшүүлэх, төрөөс дэмждэг урамшуулал, тэтгэлэг, уралдаан тэмцээнд хамруулах, орон нутгийн шилдэг дасгалжуулагч, тамирчдад тэтгэлэг олгох талаар холбогдох арга хэмжээг хяналтандаа авч ажиллаж байна. Мөн спортын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичиг, аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2025 онд хэрэгжүүлэх нийгэм, эдийн засгийн үзүүлэлт, 2025 онд хэрэгжүүлэх үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан спортын талаар хэрэгжүүлэх салбарын үйл ажиллагааг хяналтанд авч хэрэгжүүлэн ажиллаж байна. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Арга хэмжээ 1.6 Спортын арга хэмжээ, тэмцээн зохион байгуулахад шаардлагатай нөөц, санхүүгийн эх үүсвэрийг төлөвлөх | Санхүүгийн талаас тэмцээн уралдааныг саадгүй явуулсан байна. | Төлөвлөгөөнд орсон тэмцээнүүд хуваарийн дагуу бүрэн явагдах | 50% | 100% | Аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж байгаа спортын арга хэмжээ, тэмцээн зохион байгуулахад шаардлагатай төсөв, санхүүгийн эх үүсвэрийг төлөвлөх, хуваарилах, зарцуулахад хяналт тавьж ажиллаж байна. | |
| Арга хэмжээ 1.7 Ивээн тэтгэгч, хамтрагч байгууллагуудтай хамтын ажиллагаа өрнүүлэх. | Ивээн тэтгэгч, хамтрагч байгууллагуудтай хамтарч ажилласан байна. | 0 | 2 | 2 | Спортын арга хэмжээ, тэмцээн уралдаан зохион байгуулахад БТСГ-ын дэргэдэх спортын холбоод болон тус байгууллага нь MONLINE спортын бараа үйлдвэрлэгч байгууллагатай хамтран ажиллаж хувцас хэрэглэгдэхүүнээр ивээн тэтгэх, спортын тэмцээн уралдааныг хамтран зохион байгуулах зэргээр ажиллаж байна. Зарим уралдаан тэмцээнийг аймгийн ААНБ, спортын холбоод ивээн тэтгэн ажиллахын сацуу тэдгээр байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ байгуулан төрийн зарим чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100% |
| **ЗОРИЛТ 2. “ СПОРТЫН АРГА ХЭМЖЭЭ ЗОХИОН БАЙГУУЛАХ,ТАМИРЧДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ”** | | | | | | |
| Арга хэмжээ 2.1 Орон нутгийн болон үндэсний түвшний тэмцээн, уралдаан, арга хэмжээг зохион байгуулах. | Орон нутгийн болон үндэсний түвшний тэмцээн, уралдаан, арга хэмжээг зохион | Төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн байна | 50% | 100% | Улсын 4, Бүсийн 1, ААШТ 21, “Хүүхдийн спортын зуны 8-р наадам”, Бүсчилсэн хөгжил хөдөлгөөний хүрээнд Спортын их наадам, Шагайн харваа ,Сурын Харваа, Үндэсний бөх , Мөсөн сур, Мөсөн шагай ААШТ, Хөнгөн атлетикийн өсвөр үеийн ААШТэмцээн уралдаан зэргийг амжилттай зохион байгуулсан. | 100% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | байгуулсан байна | | | | | |
| Арга хэмжээ 2.2 Спортын сургалт, дасгалжуулалтыг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх | Спортын сургалт, дасгалжуулалтыг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн байна. | 0% | 50% | 100% | Спортын сургалт, дасгалжуулалтыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд дараах ажил арга хэмжээг зохион байгууллаа. Өсвөрийн шигшээ баг, тамирчдыг бэлтгэх зорилгоор Монголын хүүхдийн зуны VIII наадамд оролцсон хүүхдүүдийг шинжлэх ухааны үндсэн дээр хийгдсэн INBODY төхөөрөмжийн тусламжтайгаар бие бүтцийг тодорхойлох “Бие бялдрын чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорил”-д хамруулан цаашид хэрхэн амжилт гаргавал зохих, бие бялдрын ерөнхий хөгжил, мөчдийн ажиллах чадвар, эрүүл мэндийн үзлэг, биеийн ачаалал, биеийн бүтэц дээр гарсан сул өөрчлөлт, тамирчдын бэлтгэлжилтийн түвшин, сэргэлт, гэмтлээс сэргийлэх асуудлыг анагаах ухааны үүднээс танилцуулах талаар тамирчин хүүхдүүд болон дасгалжуулагч багш нарт заавар, зөвлөмжийг өгч мэргэжлийн туслалцааг үзүүлж байна. Мөн БТСУХ-ны харьяа Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн эмч, мэргэжилтнүүдээс өсвөрийн шигшээ багийн багш, дасгалжуулагч, арга зүйч нарт тамирчдын ур чадварыг нэмэгдүүлэх боломж, өсвөр насны хүүхдийн бие физиологын онцлогт тохирсон шинжлэх ухааны үндсэн дээр дасгал сургиулалтыг хэрхэн хийх талаар сургалтыг зохион байгууллаа. Сургалтад нийтдээ 42 албан хаагч хамрагдав. | 100% |
| Арга хэмжээ 2.3 Спортын дэд бүтцийг хөгжүүлэхэд оролцох | Спортын дэд бүтцийг хөгжүүлэхэд оролцсон байна | 0% | 50% | 100% | Эрдэнэбулган суманд 1,3,5,7-р багуудад спортын заал баригдахаар тендер зарлагдаж, газар шорооны ажил нь хийгдэж байна. Ара Арена спортын цогцолборыг 2025 оны 2-р сард шинээр ашиглалтад хүлээн авч спортын заал талбайг бүрэн ашиглаж байна. Спорт заал шинээр ашиглалтад орсноор УАШТ 4 удаа, бүсийн тэмцээн 1 удаа, ААШТэмцээн 12 удаа болхоос гадна бусад | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийтийн биеийн тамирын уралдаан тэмцээн байнга зохион байгуулагдаж байна. | |
| | Арга хэмжээ 2.4 Иргэд, хүүхэд, залуучуудыг спортоор хичээллэхэд уриалан дэмжих | Иргэд, хүүхэд, залуучуудыг спортоор хичээллэхэд уриалан дэмжсэн байна | Спортоор хичээллэсэн залуучуудын тоо | 50% | 100% | Тус хэлтэст 7 секц дугуйлан хичээлэснээр 356 хүүхэд хамрагдаж байна. Мөн Жүдо, самбо, модон барилдаан төрлийн спортын төрөл шинээр нэмэгдэж хичээллэгсдийн тоо өмнөх онтой харьцуулахад 20%-р нэмэгдсэн байна. Спортын цогцолбор шинээр ашиглалтад орсонтой холбогдуулан даам, шатар, чөлөөт бөх, үндэсний бөх, самбо бөх, волейвол, ширээний теннис, гар шагай, хөнгөн атлетикын тамирчид хичээллэх өрөө тасалгаа, заалаар хангаснаар спортоор хичээллэх тамирчдад эрүүл аюулгүй цэвэр цэмцгэр таатай орчин нөхцөлийг бүрдүүлээд байна. Спортоор хичээллэх таатай орчныг бий болгосноор спортын секц дугуйланд хамрагдсдын тоо нэмэгдэх хандлагатай байна. Ара арена спортын ордон ашиглалтанд орсноор 8 танхим нээгдэн хичээлэгсэдийн тоо нэмэгдэж, уралдаан тэмцээнд оролцогсодын тоо өмнөх оны мөн үеэс 25%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. | 100% |
| | Арга хэмжээ 2.5 Өндөр амжилтын спортын тамирчдын бэлтгэл, хөгжлийг дэмжих. | Өндөр амжилтын спортын тамирчдын бэлтгэл, хөгжлийг дэмжсэн байна. | Өндөр амжилт гаргасан тамирчдын тоо | 50% | 100% | Хугацаа болоогүй | |
| | Арга хэмжээ 2.6 | Тамирчдын хоол тэжээл, | Хэрэгжүүлсэн бодлого | 50% | 100% | Тамирчдын хоол тэжээл, нөхөн сэргээлт, эрүүл мэндийн нөхцөлийг хангах бодлого хэрэгжүүлэх ажлын хүрээнд баяр наадмын үеэр бөх барилдах бөхчүүдийг байр, | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Тамирчдын хоол тэжээл, нөхөн сэргээлт, эрүүл мэндийн нөхцөлийг хангах бодлого хэрэгжүүлэх. | нөхөн сэргээлт, эрүүл мэндийн нөхцөлийг хангах бодлого хэрэгжүүлсэн байна. | | | | хоолоор хангах, сэргэлтийн барилдааныг зохион байгуулахад дэмжлэн үзүүлэн ажиллаж байна. | |
| **ͻРИЛТ 3. " ХАМТЫН АЖИЛЛАГАА ӨРНҮҮЛЭХ, ХУУЛЬ ДҮРЭМ ЖУРАМ МӨРДҮҮЛЭХ ,СУДАЛГАА ТАЙЛАН ГАРГАХ ПОРТЫН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ "** | | | | | | |
| Арга хэмжээ 3.1 Спортын клуб, холбоод, сургалтын төвүүдийг дэмжих | Спортын клуб, холбоод, сургалтын төвүүдийг дэмжсэн байна. | Хэрэгжилт хангагдсан байна. | 50% | 100% | Спортын 5 холбоодтой хамтран ажиллах гэрээ байгуулж 28 спортын холбоотой хамтран 22 уралдаан тэмцээнийг зохион байгуулж,улс бүсийн тэмцээнүүдэд баг тамирчидаа оролцуулсан. Улсын төсөвөөс 45сая орон нутгийн төсөвөөс 48 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлээд байна. Мөн бүжгийн клубын үйл ажиллагааг дэмжин үйл ажиллагаагаа зохион байгуулхад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор заал танхимаар хангаад байна. | 100% |
| Арга хэмжээ 3.2 Спортын үйл ажиллагаатай холбоотой хууль, дүрэм, журам, стандартыг мөрдүүлэх. | Спортын үйл ажиллагаатай холбоотой хууль, дүрэм, журам, стандартыг мөрдүүлэн | Биеийн тамир спортын тухай хууль тогтоомжуудыг дагаж мөрдөх | 50% | 100% | Биеийн тамир спортын тухай хуулийн шинэчилсэн найруулга, спортын холбоотой дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажилласан байх. | | | | | |
| | Арга хэмжээ 3.3 Ажилтнуудын гүйцэтгэлд үнэлгээ өгч, урамшуулал олгох. | Ажилтнуудын гүйцэтгэлд үнэлгээ өгч, урамшуулал олгосон байна. | Хагас бүтэн жилээр албан хаагчдын үр дүнг хянасан байна. | 50% | 100% | Хэлтсийн албан хаагчдын ур чадварын тайлан болон үр дүнгийн тайланг сар бүр өгч хэвшсэн бөгөөд тайланг хэлэлцэх үеэр санал бодлоо илэрхийлэн дүгнэхэд өөрийн биеэр оролцож байна | 100% |
| | Арга хэмжээ 3.4 Иргэдийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай түншлэл хөгжүүлэх | Иргэдийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай түншлэл хөгжүүлсэн байна | Хамтран ажилласан байгууллагын тоо | 2 | 2 | Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх ажлын хүрээнд 6 спортын холбоодтой хамтран ажиллах гэрээ байгуулж, спортын уралдаан тэмцээнийг хамтран зохион байгуулж, 25,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. | 100% |
| | Арга хэмжээ 3.5 Тэмцээн, уралдааны дүрэм журмыг зөв зохистой хэрэгжүүлэхэд хяналт тавих | Тэмцээн, уралдааны дүрэм журмыг зөв зохистой хэрэгжүүлэхэд хяналт тависан байна. | Хяналт тавин ажиллах | 50% | 100% | Аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж байгаа тэмцээн, уралдааныг тухайн спортын дүрэм журмын дагуу зохион байгуулах, зөв зохистой хэрэгжүүлэхэд хяналт тавьж байна. | 100% |
| | Арга хэмжээ 3.6 | Шударга байдлыг | | 50% | 100% | Спортын уралдаан, тэмцээнийг зохион байгуулахдаа эв нэгдэл, шударга өрсөлдөөнийг хангахын тулд дараах | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Эв нэгдэл, шударга өрсөлдөөнийг хангуулах | эрхэмлэх хангуулсан байна | | | | үндсэн зарчмуудыг баримтлан ажиллаж байна. Тухайлбал:<br>1. Шударга ёс, тэгш боломжийн зарчимын хүрээнд: оролцогч бүх хүнд ижил боломж, нөхцөлийг бүрдүүлэх, шүүлт, оноолт, үнэлгээ нь ил тод, хуулийн хүрээнд байх, аль нэг баг, оролцогчид давуу байдал олгохоос зайлсхийх<br>2. Тэгш оролцооны зарчимын хүрээнд: нас, хүйс, хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран оролцох боломжийг хангах, бүх баг, тамирчдад урьдчилан мэдээлэл тэгш хүртээмжтэй очсон байх<br>3. Эв нэгдэл, хамтын ажиллагааны зарчимын хүрээнд: баг хамт олны уур амьсгалыг эерэг байлгах, тамирчид хоорондын хүндэтгэл, дэмжлэгийг урамшуулан дэмжих, үзэгч, дэмжигчдийн зан үйлийг зохистой түвшинд байлгах зохион байгуулалт хийх<br>4. Ил тод, хариуцлагатай байдлын хүрээнд: тэмцээний дүрэм, журам, шүүлтийн аргачлалыг урьдчилан олон нийтэд мэдээлэх, гарсан санал гомдолд шуурхай, шударгаар хандах, шүүгч, зохион байгуулагч нарын ёс зүй, хариуцлагыг өндөр түвшинд барих<br>5. Хүүхэд, залуучуудын хүмүүжил, төлөвшлийг дэмжих зарчимын хүрээнд: зөв үлгэр дуурайл үзүүлэх орчин бүрдүүлэх, эерэг өрсөлдөөнийг хөгжүүлэх, дарамт шахалтгүй орчинд тэмцээн явуулах<br>Дээрх зарчмыг баримтлан тэмцээн, уралдааныг гүйцэтгэснээр зохион байгуулалт сайтай, шударга, эв найртай уур амьсгалтай болж, оролцогчид болон үзэгчдийн сэтгэл ханамж өндөр байгаа болно. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| э н 3. | Арга хэмжээ 3.7 Спортын салбарын нөхцөл байдлын судалгаа хийх | Өөрийн салбарын хууль тогтоомжууд ыг судласан байна | 50% | 50% | 100% | 9-р сард хийхээр төлөвлөж байна. | ХБ |
| ). | Арга хэмжээ 3.8 Хэлтсийн үйл ажиллагааны тайлан, дүн шинжилгээг гаргаж удирдлагад тайлагнах | Хэлтсийн үйл ажиллагааны тайлан, дүн шинжилгээг гаргаж удирдлагад тайлагнасан байна | | 50% | 100% | Хэлтсийн үйл ажиллагааны тайланг хагас жилээр гарган хариуцсан албан хаагчид өгч дүн шинжилгээг гаргуулан удирдлагад тайлагнаж байна. Тус хэлтсийн 2025 оны хагас жилийн ажлын төлөвлөгөөний биелэлт 90%-тай байна. | 100% |
| 0 | Арга хэмжээ 3.9 Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг хүүхэд, гэр бүлийн хөгжил,хамгааламлын ерөнхий газар,соёл урлагын газар, биеийн тамир спортын улсын хорооны даргын хамтарсан тушаал | Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг хүүхэд, гэр бүлийн хөгжил,хамгаалалын ерөнхий газар,соёл урлагын газар, биеийн тамир спортын улсын | | 50% | 100% | Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Хүүхэд, гэр бүлийн хөгжил,хамгаалалын ерөнхий газар, Соёл урлагын газар, Биеийн тамир спортын улсын хорооны даргын хамтарсан тушаалыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд бүх дасгалжуулагч багш нартаа уг тушаалыг танилцуулан хүүхдийн эрхийг ханган ажиллах, даатгалд даатгуулах, эцэг эхийн зөвшөөрлийн авах, заавар зөвлөмж өгөх зэргээр хэрэгжүүлэн ажиллаж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хорооны даргын хамтарсан тушаалыг хэрэгжүүлнэ | | | | | |

## ХОЁР. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | | Хэрэгжилт/ хүрсэн түвшин/ | Хувь |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | | |
| Арга хэмжээ 1. Хэлтсийн ажилтнуудыг мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх. | Хэлтсийн ажилтнуудыг мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх сургалтын тоо | 5 | 3 | 3 | Спортын хэлтсийн ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх нь тухайн салбарын үйлчилгээний чанарыг сайжруулах, спортын хөгжилд бодит хувь нэмэр оруулах чухал байдаг тул дараах арга хэмжээг зохион байгуулхаар холбогдох байгууллагуудад санал хүргүүлээд байна.<br>1. Сургалт, семинар зохион байгуулах- дасгалжуулагч, шүүгч, арга зүйч, зохион байгуулагчдад зориулсан.<br>2. Туршлага судлуулах, солилцох арга хэмжээ зохион байгуулах- аймаг, бүсийн тэргүүний спортын байгууллагуудад зочлох, туршлага солилцох.<br>3. Шилдэг мэргэжилтэн шалгаруулж урамшуулах – жилийн эцсийн байдлаар шилдэг дасгалжуулагч, арга зүйч шалгаруулах | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөн сагсны дасгалжуулагчийг мэргэжил дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэн сургалтад хамруулсан. Байгууллагын зүгээс болон аймгийн ЗДТГ, дээд байгууллагаас зохион байгуулж буй сургалтад албан хаагчдыг хамруулах мөн цахимаар хамрагдах сургалтад нийтдээ 5 удаа хамрагдаад байна. | |
| | Арга хэмжээ 2. Сургалт, мэргэшүүлэх хөтөлбөрүүдэд ажилтнуудыг хамруулах | Сургалт, мэргэшүүлэх хөтөлбөрүүдэд ажилтнуудыг хамруулсан байна | 5 | 4 | 4 | БТСУХ-ны харьяа Спортын анагаах ухаан, эрдэм шинжилгээний төвийн эмч, мэргэжилтнүүдээс өсвөрийн шигшээ багийн багш, дасгалжуулагч, арга зүйч нарт тамирчдын ур чадварыг нэмэгдүүлэх боломж, өсвөр насны хүүхдийн бие физиологын онцлогт тохирсон шинжлэх ухааны үндсэн дээр дасгал сургиулалтыг хэрхэн хийх талаар сургалтыг зохион байгууллаа. Сургалтад нийтдээ 42 албан хаагч хамрагдав. | 100% |
| | Арга хэмжээ 3. Монгол бичгийн ур чадвараа дээшлүүлэх албан хэргийг хос бичгээр хөтлөн явуулах | Монгол бичгийн ур чадвараа дээшлүүлэх дунд шатны мэдлэгтэй болсон байна | | 50% | 100% | Байгууллагын зүгээс албан байгууллагуудад хүргүүлэх албан бичгийг монгол бичгээр хүргүүлэхэд нь бичиг хэргийн ажилтантай хамтран ажиллаж байна. Монгол бичгийн ур чадвараа дээшлүүлэх зорилгоор монгол бичгийн анхан шатны хичээлд хамрагдаад байна. | 100% |

ТАЙЛАН ГАРГАСАН :
БИЕИЙН ТАМИР СПОРТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА ......................................................................./Г.ЭНХ-АМГАЛАН/